БАТЛАВ
НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЛБАНЫ ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Н.ЛХАГВАСАЙХАН
2023 оны 09 сарын 14 өдөр

БАТЛАВ
МОНГОЛЫН ОЮУТНЫ ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Г.АНУДАРЬ
2023 оны 09 сарын 18 өдөр

# “ТА ТАТГАЛЗ” ЕРӨНХИЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ЗУРАГТ ХУУДАСНЫ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

**Зорилго:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” зарлигийн хэрэгжилтийг хангуулах, архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, түүний хор уршгийг олон нийтэд таниулах, зохисгүй хэрэглээний дадал, хандлагыг өөрчлөх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд оршино.

**Хамрах хүрээ:** Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Их, дээд сургуулийн бакалаврын боловсролын түвшний 1 - 4 дүгээр курсын оюутнууд оролцох боломжтой.

**Зурагт хуудаст тавигдах шаардлага:**

- “Та татгалз” арга хэмжээний агуулга, зорилгод нийцүүлсэн байна.
- ПОСТЕР зурагт хуудас нь өнгө утга санаа нь согтууруулах ундааны хор уршиг үр дүнг илэрхийлсэн байна.
- постерт агуулагдаж буй дүрслэл, хэллэгүүд нь бүх насны хүмүүс үзэхэд тохиромжтой байна.
- Зохион байгуулагчдын цахим хуудсанд байршуулж олон нийтэд түгээх тул дүрсний нягтрал шаардлага хангасан байна.
- Зохиогчийн эрх зөрчихгүй байх ашигласан тохиолдолд бүтээгчийн нэр болон бусад эх сурвалжийг тодорхой дурдсан байх.
- Ашиглаж буй элементүүд (фото зураг, чимэг зураг гм) өөрийн эсвэл оюуны өмчийн эрхтэй байна.
- Хувь хүний нэр хүнд, хувийн нууцтай холбоотой хууль зөрчсөн бүтээлийг хүлээн авахгүй.
- Бүтээл нь тухайн оролцогчийн өөрийн өмч байх (Бусдын бүтээл ашигласан тохиолдолд уралдаанаас хасахыг анхаарна уу.)
-

**Шалгаруулах журам**

- Бүтээлийг зохион байгуулагчдын сошиал хуудсанд байршуулан хандалтаар дүгнэх ба reaction, share, comment – ийн тоог харгалзан үзэж тус бүрийг 1 оноо олгох байдлаар шүүлт хийнэ.

**Хугацаа:**

- Бүтээлийг 2023.09.15-наас 2023.10.10-ныг дуустал Монголын Оюутны Холбооны facebook хуудсаар https://www.facebook.com/MongolianStudentUnion хүлээн авна.

БАТЛАВ
НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЛБАНЫ ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Н.ЛХАГВАСАЙХАН
2023 оны 09 сарын 14 өдөр

БАТЛАВ
МОНГОЛЫН ОЮУТНЫ ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Г.АНУДАРЬ
2023 оны 09 сарын 18 өдөр

**“ТА ТАТГАЛЗ” ЕРӨНХИЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ВИДЕО БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

**Зорилго:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” зарлигийн хэрэгжилтийг хангуулах, архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, түүний хор уршгийг олон нийтэд таниулах, зохисгүй хэрэглээний дадал, хандлагыг өөрчлөх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд оршино.

**Хамрах хүрээ:** Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Их, дээд сургуулийн бакалаврын боловсролын түвшний 1 - 4 дүгээр курсын оюутнууд оролцох боломжтой.

**Бичлэгт тавигдах шаардлага:**

- “Та татгалз” ерөнхий арга хэмжээний агуулга, зорилгод нийцүүлсэн байна.
- Бичлэг нь 4 минут \240 секунд\ -ээс уртгүй байна.
- Бичлэгийн зохиол болон бусад агуулагдаж буй үзэгдэл, хэллэгүүд нь бүх насны хүмүүс үзэхэд тохиромжтой байна.
- Видеог Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны болон Монголын оюутны холбооны цахим хуудаст байршуулж олон нийтэд түгээх тул түгээмэл өргөтгөл \формат\ - ыг ашиглана уу.
- Ямар нэг дуу, дүрс ашиглахдаа зохиогчийн эрх зөрчихгүй байх ашигласан тохиолдолд бүтээгчийн нэр болон бусад эх сурвалжийг тодорхой дурдсан байх.
- Видеог шууд татах боломжтой хэлбэрээр дурын Cloud drive –т байршуулж татах холбоосыг Монголын Оюутны Холбоо-ны цахим хуудас руу илгээнэ. Илгээхдээ оролцогч багийн нэр, холбогдох утасны дугаар, суралцаж буй сургуулийн мэдээллийг дэлгэрэнгүй бичихийг анхаарна уу.
- Уралдаанд ганцаарчилсан болон багаар оролцох бүрэн боломжтой.

**Шалгаруулах журам**

- Видеог зохион байгуулагчдын цахим хуудаст байршуулан нийт үзэлтээр дүгнэх ба reaction, share, comment – ийн тоо хамаарахгүйгээр нийт үзсэн минутыг харгалзан үзэж 100 минут тутамд 5 оноо олгох байдлаар шүүлт хийнэ

**Хугацаа:**

- Бичлэгийг 2023.09.20- ноос 2023.10.01-ныг дуустал Монголын Оюутны Холбооны Facebook цахим хуудсаар https://www.facebook.com/MongolianStudentUnion хүлээн авна.
- Бичлэгийг 2023.09.20-ноос 2023.10.14-ны 22.00 цаг хүртэл нээлттэй байдлаар цахим хуудаст байршуулна.

**Шагналын сан:**

- Тэргүүн байр 3.000.000 /гурван сая/ төгрөг.
- Хоёрдугаар байр 2.000.000 /хоёр сая/ төгрөг.
- Гуравдугаар байр 1.000.000 /нэг сая/ төгрөг.
- Дөрөвдүгээр байр 500.000 /таван зуу мянга/ төгрөг.
- Тавдугаар Байр 500.000 /таван зуу мянга/ төгрөг.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ,
ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЛБА

- МОНГОЛЫН ОЮУТНЫ ХОЛБОО -

БАТЛАВ
НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЛБАНЫ ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Н.ЛХАГВАСАЙХАН

2023 оны 09 сарын 14. өдөр

БАТЛАВ
МОНГОЛЫН ОЮУТНЫ ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.АНУДАРЬ

2023 оны 09 сарын 18 өдөр

**"ТА-ТАТГАЛЗ" ЕРӨНХИЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ЦАХИМ СҮЛЖЭЭ ДЭХ ТҮГЭЭЛТИЙН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

**Зорилго:** Ерөнхий арга хэмжээний хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны цахим хуудаст нийтлэгдэж буй контент /видео мэдээлэл, постер болон бусад мэдээ мэдээлэл/-ийг 18 - 25 насны залуучуудад хүргэх мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэхэд оршино.

**Хамрах хүрээ:**

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Их, дээд сургуулийн оюутны холбоо, зөвлөл, клубууд оролцох боломжтой.

**Зохион байгуулагдах хэлбэр:**

Ерөнхий арга хэмжээний хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны цахим хуудаст нийтлэгдэж буй бүх контент /видео мэдээлэл, постер болон бусад мэдээ мэдээлэл/-ийг өөрсдийн цахим хуудастаа түгээлт /share/ хийж байршуулж хамгийн их хандалт /Like, share, reach/ авсан оюутны холбоо, зөвлөл, клубыг шалгаруулна.

Бодит хандалт /Like, share, reach/-аар тооцож шалгаруулна. Төлбөртэй сурталчилгааны замаар авсан хандалтыг тооцохгүй.

**Хугацаа:**

- 2023.09.18 – 2023.10.18-ныг дуустал

**Шалгаруулах журам**

Тэмцээнд оролцох хүсэлт, цахим хуудасны мэдээллийг 2023 оны 09 дүгээр сарын 15 - 19-ний хооронд https://www.facebook.com/hevjurmiinalba цахим хаягийн захидал хэсгээр хүлээн авна.

Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба болон Монголын оюутны холбооноос бүрдсэн шүүгчдийн бүрэлдэхүүн шалгаруулалтыг зохион байгуулна.

**Шагнал урамшуулал**

- Тэргүүн байр 6.000.000 /зургаа сая/ төгрөг.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ, ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЛБА

- МОНГОЛЫН ОЮУТНЫ ХОЛБОО -

- Бүтээлийг  2023.09.15-наас эхлэн 2023.10.10-ны 22.00 цаг хүртэл нээлттэй байдлаар цахим хуудаст байршуулна.

**Шагналын сан:**

- Тэргүүн байр 2.000.000 /хоёр сая/ төгрөг.
- Хоёрдугаар байр 1.000.000 /нэг сая/ төгрөг.
- Гуравдугаар байр  500.000 /таван зуу мянга/ төгрөг.
- Дөрөвдүгээр байр 500.000 /таван зуу мянга/ төгрөг.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ,
ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЛБА

- МОНГОЛЫН ОЮУТНЫ ХОЛБОО -